

ОНЛАЙН БРОКЕР

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

2024

dbx.sgis.mn



1


**ХЯНАЛТЫН
САМБАР
ЦЭС**

2024

1 ХЯНАЛТЫН САМБАР ЦЭС

Хяналтын самбар цэснээс дараах мэдээллүүдийг харах боломжтой.

- Дансан дахь үнэт цаасыг мөнгөн дүнгээр тооцон графикаар харах
- Дансан дахь үнэт цаасны үлдэгдэл, хувьцаа тус бүрээр хуулга харах
- Дансан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлүүд /ҮЦТХТ, Номинал данс/



Зураг 5

2 ДАНСНЫ ХУУЛГА ЦЭС

Дансны хуулга цэснээс дараах мэдээллийг харах боломжтой.

- ГҮЙЛГЭЭНИЙ ТҮҮХ
- ҮЛДЭГДЭЛ

ГҮЙЛГЭЭНИЙ ТҮҮХ: Тус цэсийг сонгон бүх гүйлгээг эсвэл хайх хэсгийг сонгож дурын үнэт цаасаар, хугацаагаар тохируулан өөрийн данс дахь арилжааны дэлгэрэнгүй гүйлгээ буюу хуулгыг харах боломжтой.

Гүйлгээний түүх

Экспорт товчийг дарснаар гүйлгээний түүхээ эксел файлаар авах боломжтой

№	Огноо	Үнэт цаасны нэр	Симбол	Код	Оролого	Зарлага	ХСО	ХСБ	Үнэ	Нийт дүн	Шантгад	Тайлбар
1	2024-04-01	ТАВАН ТӨЛӨГӨЙ	TTL	458	3				29,000.00	87,000.00	870.00	ҮЦ худалдан авсан 2024-03-28
2	2024-04-01	9995-Номинал: Бэлэн мөнгө	9995	9995	0.00	11,009.00			0.00		0.00	2410849 Y021281892 APU 2024-04-01
3	2024-04-01	АПУ	APU	90	10				1,090.00	10,900.00	109.00	ҮЦ худалдан авсан 2024-03-28
4	2024-04-01	9995-Номинал: Бэлэн мөнгө	9995	9995	0.00	1,514.90			0.00		0.00	2410849 Y021281892 CLMN 2024-04-01
5	2024-04-01	Смарт Экспресс: Сн Вн 3с ХХ	CLMN	557	10				149.99	1,499.90	15.00	ҮЦ худалдан авсан 2024-03-28

Зураг 6

ҮЛДЭГДЭЛ: Тус цэсийг сонгосноор өөрийн дансанд дахь үнэт цаасны үлдэгдэл болон мөнгөний үлдэгдлийг нийтээр болон тухайлсан байдлаар, мөн сонгосон хугацаагаар харах боломжтой.

Онлайн Брокер үйлчилгээ | SG INVESTMENT & SECURITIES

Дансны үлдэгдэл

Үнэт цаасны үлдэгдэл | Мөнгөний үлдэгдэл

Хайх

Огноогор шуук харгалдаа дуусаа огноог нь Т-2 огноогор шууу үү.
ХВ0 - Хуульдаж буй орлого
ХВ3 - Хуульдаж буй зарлага

№	Код	Үнэт цаас	Эзний үлдэгдэл	Орлого	Зарлага	ХВ0	ХВ3	Эцсийн үлдэгдэл
1	APU	АПУ	10					10
2	GOV	ГОВ	5					5
3	MSE	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	10					10
4	CLMN	Сингап Экспресс Ся Би Эс ХХ	10					10

Зөвлөгөө

Зураг 7

3 ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ ЦЭС

Онлайн Брокер үйлчилгээ | SG INVESTMENT & SECURITIES

Өгөөжийн тооцоолол

Хайх

19,666.72 ₮
Нийт хөрөнгө оруулалт

19,682.00 ₮
Одоогийн үнэлгээ

15.28 ₮
Ашиг/Алдагдал (Төгрөгөөр)

0.08%
Ашиг/Алдагдал (Хувиар)

Хувьцаа (Сембли)	Хувиараа авсан үнийн үнэлгээ				Одоогийн үнэлгээ			Ашиг/Алдагдал	
	Тоо ширхэг	Дундаж үнэ ₮	Шалтга ₮	Үнийн дүн ₮	Хэзэвч хэвч ₮	Шалтга ₮	Үнийн дүн ₮	Төгрөгөөр	Хувиар
KHAN	10	1,136.00	113.60	11,479.60	1,053.00	0.00	10,530.00	-943.60	-8.22%
MNDL	104	78.00	81.12	8,199.12	88.00	0.00	9,152.00	958.88	11.70%
Нийт	114		194.72	19,668.72		0.00	19,682.00	15.28	0.08%

Нийт ашиг, алдагдлын хэмжээ /мөнгөн дүнгээр/

Нийт ашиг, алдагдлын хэмжээ /хувиар/

Зураг 8

4 АШГИЙН ТООЦООЛОЛ ЦЭС

Ашгийн тооцоолол цэснээс дараах мэдээллүүдийг харах боломжтой.


- Дансан дахь хөрөнгө оруулсан хөрөнгийн хэмжээ
- Нийт төлсөн шимтгэлийн хэмжээ
- Одоогийн байдлаарх ашиг, алдагдлын хэмжээ /мөнгөн дүнгээр/
- Тухайн өдрийн хаалтын ханшийн мэдээ

№	Симбол	Асан (т.л)	Зарсан (т.л)	Үлдэгдэл (т.л)	Хөрөнгө оруулалт	Шингэл	Зарсан дүн	Одоогийн үнэмлэг	Ашиг/Алдагдал	Хаалтын ханш	Хамгийн өгөө
1	KHMN	10		10	11,360.00	113.60	0.00	10,530.00	-945.60	1,053.00	2024-04-05
2	MNDL	104		104	8,112.00	81.12	0.00	9,152.00	958.88	88.00	2024-04-05
Нийт:					19,472.00	194.72	0.00	19,682.00	15.28		

Зураг 9

5 МИНИЙ БАГЦ /ДЕМО/ ЦЭС

Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцож турших, арилжаанд оролцох тодорхой мэдлэгтэй болох зорилгоор бодит бус /демо/ арилжаа хийх боломжтой бөгөөд багц бүрдүүлж ашиг алдагдлын хэмжээгээ тооцоолж болно.




Зураг 10

6 АРИЛЖАА ЦЭС

1. ЗАХИАЛГА


Шинээр захиалга илгээхдээ **Арилжаа – Захиалга** гэсэн хэсгийг сонгоно. **Захиалга** хэсгийг сонгоод **Үнэт цаас сонгох** – хэсэгт захиалга илгээх үнэт цаасны нэрийг бичнэ.



Зураг 11

Үнэт цаас сонгох

Энэ хэсэгт захиалга илгээх хувьцааны нэрийг бичснээр дараах талбар /Зураг.10/ гарч ирэх ба баруун гар тал дахь **Захиалга өгөх** – хэсэгт авах, зарах сонголтыг сонгон захиалгын нөхцөлүүдийг оруулах боломжтой болно.



Зураг 12

2. ЗАХИАЛГЫН ЖАГСААЛТ

Таны илгээсэн захиалгууд жагсаалтаар харагдах бөгөөд тухайн захиалга биелэгдсэн, цуцлагдсан, хугацаа дууссан эсэхийг захиалга бүрийн ард талын **Төлөв** – хэсгээс харах боломжтой.

№	Хувьцаа	Төрөл	Үнэ	Тоо ширхэг	Биелсэн	Үлдсэн	Төлөв	Огноо ↓	Нийт	Шантгал	Хугацаа
1	APU	ХААР	1,086.00	1	0	0	Түгэлсэнгүй	2024-04-05 17:45:05	1,086.00	10.86	GTС
2	APU	ХААР	1,090.00	10	10	0	Биелсэн	2024-03-28 11:48:35	10,900.00	109.00	GTС
3	TTL	ХААР	29,000.00	3	3	0	Биелсэн	2024-03-28 11:45:29	87,000.00	870.00	GTС
4	CUMN	ХААР	150.00	10	10	0	Биелсэн	2024-03-28 11:39:24	1,500.00	15.00	GTС
5	TTL	ХААР	28,500.00	3	0	0	Цуцлагдсан	2024-03-28 11:38:13	85,500.00	855.00	GTС
6	GOV	ХААР	262.00	5	5	0	Биелсэн	2024-03-26 11:21:12	1,310.00	13.10	GTС
7	CUMN	ХААР	10.00	145	0	0	Цуцлагдсан	2024-03-26 11:19:17	1,450.00	14.50	GTС
8	TUM	ХААР	340.00	10	10	0	Биелсэн	2024-03-26 11:18:09	3,400.00	34.00	GTС
9	MSE	ХААР	165.00	10	10	0	Биелсэн	2024-03-26 11:17:08	1,650.00	16.50	GTС

Зураг 13

3. ЗАХИАЛГЫН ЦУЦЛАХ

Та захиалгын урд байрлах "x" тэмдэглэгээ дээр дарж илгээсэн захиалгаа цуцална. Захиалга өөрчлөх бол өмнөх захиалгаа цуцлаад шинээр захиалгаа илгээнэ.

№	Хувьцаа	Төрөл	Үнэ	Тоо ширхэг	Биелсэн	Үлдсэн	Төлөв	Огноо ↓	Нийт	Шантгал	Хугацаа
1	APU	ХААР	1,086.00	1	0	0	Түгэлсэнгүй	2024-04-05 17:45:05	1,086.00	10.86	GTС
2	APU	ХААР	1,090.00	10	10	0	Биелсэн	2024-03-28 11:48:35	10,900.00	109.00	GTС
3	TTL	ХААР	29,000.00	3	3	0	Биелсэн	2024-03-28 11:45:29	87,000.00	870.00	GTС
4	CUMN	ХААР	150.00	10	10	0	Биелсэн	2024-03-28 11:39:24	1,500.00	15.00	GTС
5	TTL	ХААР	28,500.00	3	0	0	Цуцлагдсан	2024-03-28 11:38:13	85,500.00	855.00	GTС
6	GOV	ХААР	262.00	5	5	0	Биелсэн	2024-03-26 11:21:12	1,310.00	13.10	GTС
7	CUMN	ХААР	10.00	145	0	0	Цуцлагдсан	2024-03-26 11:19:17	1,450.00	14.50	GTС
8	TUM	ХААР	340.00	10	10	0	Биелсэн	2024-03-26 11:18:09	3,400.00	34.00	GTС
9	MSE	ХААР	165.00	10	10	0	Биелсэн	2024-03-26 11:17:08	1,650.00	16.50	GTС


Зураг 14

7 IPO ЗАХИАЛГА ЦЭС

Анхдагч зах зээлийн захиалга буюу шинээр гарч буй үнэт цаасыг худалдан авах захиалга илгээхэд дараах зүйлсийг мэдэх хэрэгтэй.

- Хувьцаа худалдан авах мөнгөө шимтгэлийн хамт захиалга илгээхээс өмнө урьдчилан байршуулах /зааврын дагуу байршуулна/


IPO захиалга – Сонгох /байршуулсан мөнгөндөө тааруулж худалдан авах хувьцааны хэмжээгээ оруулан захиалга илгээнэ/



Зураг 15

1. IPO СОНГОХ

IPO захиалга цэс рүү нэвтрэн үнэт цаасаа сонгох



Зураг 16

2. ЗАХИАЛГЫН ТӨРӨЛ СОНГОХ

Дансны үлдэгдлээ шалган “Захиалгын төрөл” хэсэгт “Нөхцөлт” хэлбэрийг сонгон “Захиалга өгөх” товч дарах.

IPO сонгох

Дансны үлдэгдэл: 0.00 → үнэт цаасны дансны үлдэгдэл /мөнгөн төгрөгөөр/

ТЕСТ : TEST

Нийт захиалгын тоо: 0
Нөхцөлт: нийт захиалсан ширхэг: 0

Захиалгын төрөл: *
Нөхцөлт

Үнэ: *
100.00

Тоо ширхэг: *
Тоо ширхэг → Захиалга өгөх тоо ширхэг оруулах

Шимтгэл:
1.00%

Нийт (Дүн + Шимтгэл):
0 → Өгсөн захиалгын дүн шимтгэлийн хамт нийт дүн болж харагдана


Захиалга өгөх → Захиалгаа шалган хамгийн сүүлд дараах товчийг дарснаар захиалга илгээгдэх болно

Зураг 17

8 МӨНГӨ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ ЦЭС

1. НОГДОЛ АШГИЙН МӨНГӨ АВАХ /ҮЦТХТ/


Харилцагч “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн үнэт цаасны дансан дахь хөрөнгийг өөрийн нэр дээрх банкны данс руу шилжүүлэхдээ энэхүү хүсэлтийг илгээнэ. Мөнгө хүсэх өргөдлийн хүсэлтийг онлайнаар илгээхээс өмнө харилцагч нь ҮЦТХТ-ийн **“Мөнгөн хөрөнгийн гүйлгээний гэрээ”**-г байгуулсан байх шаардлагатай.



Зураг 18

2. МӨНГӨ АВАХ /ХОЁРДОГЧ АРИЛЖААНЫ/ - НОМИНАЛ ДАНС

Харилцагч таны хувьцаа зарсан болон хувьцаа худалдан авахаар байршуулсан мөнгө арилжааны мөнгөн төлбөр тооцооны номинал дансанд байршдаг. Та онлайн системээрээ дамжуулж мөнгө гаргуулах хүсэлт илгээх боломжтой. Харин гаргах мөнгөн дүнгээс худалдан авахаар хүлээгдэж байгаа болон захиалгын санд зоолттой авах захиалгын дүнг хасч тооцсон байх шаардлагатай.



Зураг 19

9 ТУСЛАМЖ ЦЭС

Тусламж болон Чат цэс рүү хандаж санал хүсэлтээ илгээж ажилтантай холбогдон дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

10 НЭВТРЭХ НУУЦ ҮГ СЭРГЭЭХ, СОЛИХ ЦЭС

1. НУУЦ ҮГ СЭРГЭЭХ


Хэрэв нэвтрэх нууц үгээ мартсан бол **Нууц үг сэргээх** хэсгийг сонгон бүртгүүлсэн и-мейл хаягаа оруулж сэргээнэ.



Зураг 20

2. НУУЦ ҮГ СОЛИХ

Нууц үг солих бол Хэрэглэгч ***** нэвтрэх **Нууц үг солих** гэсэн хэсэгт орж нууц үгийг солино.



Зураг 21



2 ТУСЛАМЖ

2024



1 ТУСЛАМЖ, АНХААРУУЛГА

1. АРИЛЖААНЫ ЦАГ

Монголын хөрөнгийн биржийн арилжаа нь ажлын өдрүүдэд дараах цагийн хуваариар явагддаг:

- Арилжаа 10:00-13:00 цагийн хооронд явагддаг ба 13:00 цагаас өмнө илгээсэн захиалга тухайн өдрийн арилжааны санд орно.
- 13:00 цагаас хойш, ажлын бус цагаар, амралтын өдрүүдэд илгээсэн захиалга дараагийн ажлын өдрийн арилжааны цагаар захиалгын санд шивэгдэнэ.

2. ТӨЛБӨР ТООЦООНЫ НОМИНАЛ ДАНСАН ДАХЬ БЭЛЭН МӨНГӨ

ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОХ МӨНГӨ БУЮУ ҮНЭТ ЦААС ХУДАЛДСАН БОЛОН ХУДАЛДАН АВАХ МӨНГӨ.

Харилцагчийн арилжааны цагаар, ажлын өдрүүд, амралтын өдрүүдэд төлбөр тооцооны Номинал дансанд мөнгө байршуулахдаа брокерийн өгсөн зааврын дагуу гүйлгээний утга дээр нэр, регистрийн дугаар бичиж байршуулах ба зааврын дагуу байршуулсан бол мөнгөн орлогын гүйлгээ нь бэлэн мөнгө хэсэгт шууд харагдана. Харин гүйлгээний утга тодорхойгүй байршуулсан бол ҮЦК гүйлгээг хянаснаар үлдэгдэлд харагдах боломжтой.

3. ТӨЛБӨР ТООЦОО ХИЙГДЭХ ӨДӨР

Монголын Хөрөнгийн Биржийн хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо T+2 журмын дагуу явагддаг ба энэ нь таны худалдан авсан болон худалдсан үнэт цаас, түүний мөнгөн төлбөр тооцоо ажлын хоёр өдрийн дараа хийгддэг зохицуулалттайг анхаарах шаардлагатай.

4. ХУВЬЦААНЫ ҮНЭ БУЮУ TICK SIZE

Монголын Хөрөнгийн Биржийн системийн онцлогоос хамааран харилцагч захиалга өгөхдөө хувьцааны үнийг дараах байдлаар оруулна.

ХУВЬЦААНЫ ҮНЭ /ТӨГРӨГ/	ХУВААГДАХ ТОО
1,000-с доош	0.01 мөнгө
1,000-5,000	1 төгрөг
5,000-10,000	5 төгрөг
10,000-20,000	10 төгрөг
20,000-40,000	20 төгрөг
40,000-50,000	40 төгрөг
50,000-80,000	50 төгрөг
80,000-100,000	80 төгрөг
100,000-с дээш	100 төгрөг

Үл хуваагдах ханшийг оруулсан тохиолдолд захиалга амжилтгүй болохыг анхаарна уу.

5. ЗАХИАЛГЫН ХУГАЦАА, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

Харилцагч захиалгаа биелэгдэх өдөр хүртэл буюу 30 хүртэлх өдрийн хугацаагаар эсвэл заасан хугацаа хүртэл хүчинтэй байх нөхцөлөөр захиалга илгээх боломжтой.

Захиалгын хугацаа:

- GTC – Таны захиалга 30 хоногын хугацаанд захиалгын санд байршина.
- GTD – Захиалгын санд байрших хоногийг тодорхой зааж өгнө.
- DAY – Зөвхөн захиалга өгсөн өдөртөө захиалгын санд байршина.
- GTT – Уг захиалга нь захиалга өгсөн өдрийн арилжааны тодорхой цаг минут хүртэл хүчинтэй байршина.

6. ХАНШИЙН ХЯЗГААР

Монголын Хөрөнгийн Биржийн системийн онцлогоос хамааран худалдах, худалдан авах захиалгын биелэх боломжтой ханшийн дээд доод хязгаар өмнөх өдрийн хаалтын ханшнаас ± 15 хувийн дотор байдаг.

7. ДУУДЛАГА АРИЛЖАА

Монголын Хөрөнгийн Биржийн журмаар хувьцааны тухайн өдрийн арилжааны сүүлийн ханшаас ± 5 хувиар биелэгдэх захиалга нь дуудлага арилжааны горимд шилждэг. Энэ үед худалдан авах, худалдах талууд ханшаа өөрчлөх боломжтой бөгөөд өөрчлөлт хийх 5 минут хүлээх горимд шилждэг.

8. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД ЗАХИАЛГА ӨГӨХ

Захиалга хэсгээс анхдагч зах зээлийн арилжаа буюу IPO ЗАХИАЛГА хэсгийг сонгон захиалгаа илгээнэ. Хувьцааны үнэ тоо ширхэгийг оруулахдаа тухайн үнэт цаасны танилцуулга, захиалга биелэгдэх журамтай танилцсаны үндсэн дээр илгээх. Одоогийн зохицуулалтгаар анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог “Үнэт цаас төвлөрсөн хадгалаламжийн төв” ХХК гүйцэтгэж байгаа тул үнэт цаасны дансанд мөнгө байршуулах болон бусад мэдээллийг ҮЦК-иас тухай бүр авах шаардлагатай.

9. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРТГЭЛИЙН ӨДӨР

- **Бүртгэлийн өдөр** гэдэг нь хувьцаат компаниас тухайн жилийн ногдол ашиг авах болон ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг эцэслэн гаргадаг өдөр бөгөөд бүртгэлийн өдрийн байдлаар компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ХЭХ-д оролцох, ногдол ашиг хүртэх эрхтэй.
- **Бүртгэлийн өдөрт орох сүүлийн хугацаа** гэдэг нь тухайн хувьцааг худалдан авахад бүртгэлийн өдөрт багтаж, ногдол ашиг хүртэх боломжтой болох сүүлийн өдөр юм.

Монголын хөрөнгийн биржийн систем нь T+2 буюу арилжааны хэлцэл биелсэнээс 2 хоногийн дараа төлбөр тооцоо гүйцэтгэдэг. Иймд тухайн үнэт цаасыг худалдаж авсан тохиолдолд 2 хоногийн дараа үнэт цаас дансанд байршдаг учир бүртгэлийн өдрөөс ажлын 2 хоногийн өмнө тухайн үнэт цаасыг худалдан авсан байх шаардлагатай.

10. ҮЦК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮЛ ХАМААРАХ СААТАЛ

Харилцагч захиалгаа илгээх болон илгээсэн захиалгыг оруулах явцад оролцогч байгууллага Монголын Хөрөнгийн Биржийн үйл ажиллагаа, арилжааны систем, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Арилжаа төлбөр тооцоо байгууллагын үйл ажиллагаа саатах ҮЦК-ийн үйл ажиллагаа саатах ҮЦК-ийн үйл ажиллагаанд давагдашгүй хүчин зүйлс, тогны хязгаарлалт хийгдсэн зэрэг шалтгааны улмаас захиалга биелээгүй, захиалгын санд оруулах боломжгүй нөхцөл үүссэн бол ҮЦК хариуцахгүй.

11. ХУВЬЦААНЫ ТАЛААР

Хувьцаа худалдан авснаар

- Хувьцаа эзэмшигчээр бүртгэгдэх
- Ханшийн зөрүүнээс ашиг олох
- Ногдол ашиг авах
- Компанийн удирдлагын шийдвэр гаргалтад нөлөөлөх

Монголын Хөрөнгийн Биржийн нээлттэй арилжаанд иргэн болон хуулийн этгээд өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан оролцох ба хувьцаа худалдан авч, хөрөнгө оруулалт хийснээр та эзэмшиж буй хувьцаанаасаа ногдол ашиг хүртэх, ханшийн зөрүү буюу хэлбэлзлээс ашиг олох, түүнчлэн хувьцааг нь эзэмшиж буй компанийхаа удирдлагын шийдвэр гаргалтад нөлөөлөх эрхтэй болох боломжууд үүсдэг.

Хувьцаа худалдан авахдаа дараах зүйлсийг анхаарах. Үүнд:

- Компанийн удирдлага, менежмент

Таны оруулсан хөрөнгийг аль болох оновчтой, ашигтайгаар зарцуулж, зөв менежментийг хэрэгжүүлэх, түүнээс хувьцаа эзэмшигч танд буцаан өгөөж бий болгох эсэх нь компанийн удирдлага, менежментээс хамааралтай.

Салбарын чиг хандлага, цаг үеийн мэдээ

Тухайн байгууллагын үйл ажиллагаагаа явуулж буй салбар, түүний онцлог, цаашдын чиг хандлага, эрх зүйн орчин, эдийн засгийн нөлөөллүүдийг анхаарах нь зүйтэй. Тухайн салбарт болж буй онцлох үйл явдлууд, гадаад зах зээлийн нөлөө, хууль журмын өөрчлөлт гэх мэт зүйлс компанийн үйл ажиллагаа, цаашлаад хувьцааны ханшид тодорхой хэмжээнд нөлөөлдөг.

Санхүүгийн байдал

Аж ахуй нэгж, байгууллагын санхүүгийн тайлантай танилцаж, дүгнэлт өгөх нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад чухал ач холбогдолтой. Ашиг, алдагдал, өр, авлага гэх мэт хэд хэдэн гол үзүүлэлтүүдээр компанийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж болдог.

Хувьцааны бодит үнэ

Хувьцааны үнэ өсөж, бууран хэлбэлзэж байдаг ба хөрөнгө оруулагч та зах зээлийн үнэ болон хувьцааны дансны үнэ хоёрын зөрүүг харгалзан шийдвэрээ гаргах нь зүйтэй.

- Дансны үнэ (BV)=Эздийн өмч/Хувьцааны тоо ширхэг
- Үнэ, дансны үнийн харьцаа (P/B)=Зах зээлийн үнэ/Дансны үнэ

$(P/B) < 1$ бол тухайн компанийн хувьцаа зах зээл дээр багаар үнэлэгдсэн, харин $1 < (P/B)$ бол өндрөөр үнэлэгдсэн гэж үздэг. Үнэлгээ бага байвал цаашид хувьцааны ханш өсөх, үнэлгээ их байвал ханш буурах магадлалтайг илэрхийлнэ.

Хувьцааны ханшийн савалгаа

Нээлттэй арилжаалагдаж буй хувьцаануудын ханш нь янз бүрийн хүчин зүйлсээс шалтгаалан дээш доош хэлбэлзэж байдаг. Гэнэтийн, огцом өсөлт, уналтаас ашиг олж болох хэдий ч ханшийн өөрчлөлтийн хэмжээг дагаж хүлээж болзошгүй алдагдал буюу эрсдэлийн хэмжээ ч нэмэгдэж байдаг.

Ногдол ашиг

Компани тухайн тайлант жилийн хугацаанд ашигтай ажиллан, ашгаасаа тодорхой хувийг хувьцаа эзэмшигчдэд тараадаг. Ихэнхдээ үйл ажиллагаа нь тогтворжсон, зах зээлд байр сууриа олсон, сайн засаглалтай компаниуд ногдол ашиг тогтмол тараах хандлагатай байдаг.

Хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл

Нээлттэй хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн талаар судлах нь зүйтэй. Олон нийтэд нээлттэй арилжаалагдаж буй хувьцааны тоо ширхэг, хувь хэмжээ бага бол таны худалдан авсан хувьцааны хөрвөх чадвар муудах, арилжааны идэвх багасах зэрэг эрсдэл үүснэ.